

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ**

**ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ**

*/2020 оны 2 сарын байдлаар/*

№	Үзүүлэлт	<i>БОЭТ</i>	<i>Сумдын эмнэлэг</i>	<i>Өрхийн эмнэлэг</i>	<i>Хувийн эмнэлэг</i>	<i>Цэргийн анги</i>	<i>Нийт дүн</i>
1	Нийт үзлэг	14440	18735	11867	6484	730	52256
2	Урьдчилан сэргийлэх үзлэг	2997	4269	1266	464	639	9635
3	Идэвхтэй хяналтын үзлэг	1600	4756	5071	706	1	12135
4	Бүртгэгдэж эмчлэгдсэн өвчлөл	4062	4973	3723	1574	68	14400
5	Нийт төрөлт	243	56				299
6	Хэвтэн эмчлүүлэгчид	1413	1166		371	3	2953
7	Нас баралт	11	27	21			59

- Улсын болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд нийт 52256 хүнд үзлэг шинжилгээ хийсний 41,6 %-д нь урьдчилан сэргийлэх болон идэвхтэй хяналт тандалтын үзлэг хийгдсэн байна.
- Ортой эмнэлгүүдэд нийт 2953 хүнийг 18401 ор хоногоор хэвтүүлэн эмчилсэн нь нэг хүн дунджаар 6.2 хоног хэвтэн эмчлүүлсэн байна.
- 2 сарын байдлаар 14400 халдварт бус өвчлөл шинээр бүртгэгдэж эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 350 тохиолдлоор өссөн байна.
- 2 сарын байдлаар 202 хүн осол гэмтэлд өртсөний улмаас тусламж авсан ба осол гэмтлээр 8 хүн нас барсан нь өнгөрсөн оноос өвчлөл 16 тохиолдлоор өсч , осол гэмтлийн нас баралт өнгөрсөн оны түвшинд байна. Осол гэмтлээр нас барагсдын 50%/4 /нь зам тээврийн осол-Нн-1,3Д -2,БУ-1 50%/4/нь бусад ослоор/Бд-1, БУ-1, ГТ-1 ЭХ-1/ тус тус эндсэн байна. Осол гэмтлээр нас барагсад нь 66,6% /6/ эрэгтэй хүмүүс эндсэн ба 2 нь эмнэлэгт хүргэгдсэн боловч хоног болоогүй нас барсан байна. Бусад тохиолдлууд эмнэлгийн ямар нэг тусламж авч чадаагүй газар дээрээ нас барсан байна.
- Оны гарсаар 59 хүн нас барсан ба нийт нас барсан хүний 13,5 % нь осол гэмтлээр, 23,7% нь хорт хавдраар, 13.5% нь зүрхний шигдээс, тархинд цус харвалт зэрэг сэргийлж болох эндэгдэлээр, 5% нь нярай үеийн эмгэгийн улмаас нас барсан байна.
- Нялхсын эндэгдлийн 5 /Цц-2,Шб-2 ГТ-1/тохиолдол бүртгэгдсэн нь 1000 амьд төрөлтөд 16,7 байна.
- Түргэн тусламжийн 3015 дуудлагад явж үйлчилсний 413 /13,6%/ нь алсын дуудлага, 74 /2,4%/ нь осол гэмтлийн яаралтай дуудлага байсан байна. Нийт дуудлагын 51,4 % -д 0-20 минутны дотор гарч үйлчилсэн байна .
- 2 сарын байдлаар 7055 хүүхдийг идэвхтэй хянаж, хооллолт өсөлт хөгжилтийн байдлыг үнэлэн зөвлөгөө дэмжлэг үзүүлсэн нь хяналтад хамрагдвал зохих хүүхдийн 42,7% эзэлж байгаа нь хангалтгүй байна. Хяналтанд хамрагдсан хүүхдүүдээс 11 хүүхэд жингийн алдагдалтай байгаа нь нийт хүүхдийн 0,15%-г эзэлж байна.
- Нийт 299 эх төрж 301 хүүхэд мэндэлсэн нь өнгөрсөн онтой харьцуулахад 70 төрөлтөөр хүн амын төрөлт өссөн байна. Нийт төрсөн хүүхдийн хүйсийн харьцаа 1,1:1 байгаа ба эрэгтэй хүйс давамгайлж байна. Нийт төрөлтийн 13/4,3%/ охидын төрөлт эзэлж байгаа нь анхаарал татаж байгаа үзүүлэлт байна./Гт-1,Мн-3,Цо-1, Цц-1,Өо-1, Эх-1 НО-2 , ХБ-2, ХҮ-1/.
- 2 сарын байдлаар 101 эх үр хөндүүлж 1000 амьд төрөлтөд 338,9 байгаа нь өнгөрсөн оноос 9,9% өссөн үзүүлэлт байна.Өсвөр насны охидын үр хөндөлт-4 /3,9% /Мо-1,Шб-3/ байна.
- Он гараад 142 халдварт өвчин бүртгэж эмчилсэн нь өнгөрсөн оноос 73 тохиолдлоор өссөн байна. Нийт халдварт өвчний 53,5%-г салхинцэцэг, 3,5%-г гар хөл амны өвчин,35,9%-г БЗДХ өвчин тус тус эзэлж байна.
- Нийт эмийн сангууд 7809 жор хүлээн авч, 888,2 сая төгрөгний эм бараа борлуулалт хийсэн байна.
- ЭЭСангуудад нийт 3710 жор ирсний 47,8% /1776/ нь ЭМДаатгалын, 2,6%/99/ мансууруулах сэтгэц нөлөөт эмийн, 49,4% /1835/ нь энгийн эмийн жор байсан байна. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт дундажаар 78.4 % байна.
- БОЭТөвд 11 эндэгдэл тохиолдож 10 задлан шинжилгээнд хамруулсан ба задлан шинжилгээний хувь 90,9% тай байна. Үндсэн оношийн зөрөө 1.